



**ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2025 оны 09 сарын 16 өдөр

Дугаар A/315

Улаанбаатар хот

**Хяналт шалгалт хийх ажлын хэсэг
байгуулах тухай**

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн хяналт шалгалтын тухай хууль Тамхины хяналтын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.7.12, 6.7.7, 6.7.8, 6.7.14, 11 дүгээр зүйлийн 11.1, 11.2, 11.3 "Тамхины үйлдвэрлэл, импорт, худалдаа, үйлчилгээнд хяналт тавих журам"-ын 5 дугаар зүйлийн 5.1.4, 5.2.2, Нийслэлийн нутаг дэвсгэрт худалдаа үйлчилгээ эрхлэх нийтлэг журмын 8.1.13, Монгол Улсын эрүүл мэндийн сайдын А/74 дүгээр тушаал, Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хуулийн 12 дугаар зүйл 12.1, 12.1.1, 12.3 заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хүүхдийн эрүүл, аюулгүй орчинд сурч боловсрох нөхцөл боломжийг бий болгох зорилгоор дүүргийн нутаг дэвсгэрийн ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн цайны газар, гал тогоо, сургууль орчмын хүнсний дэлгүүрүүдэд хяналт шалгалт хийх, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах чиг үүрэг бүхий ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, удирдамжийг хоёрдугаар, хуваарийг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Дээрх ажлыг үр дүнтэй зохион байгуулж, хийж хэрэгжүүлсэн ажлын тайланг 2025 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн дотор танилцуулж ажиллахыг Ажлын хэсэг (Л.Цэеэрэгзэн)-т үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газар (Ж.Тамир)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Н.МАНДУУЛ

1525010955